

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



**УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР**

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРОО**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 35
1.	<i>Конвенц соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.04.30-ний өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/</i>	6 – 9
2.	<i>Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	10 – 35

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 27-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 45 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Тулга, Г.Хосбаяр;

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, С.Лүндэг, Ц.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Энхбаяр, Л.Энхнасан, С.Эрдэнэболд;

Тасалсан: О.Амгаланбаатар, Б.Батбаатар, Х.Тэмүүжин.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг ирэх долоо хоног хүртэл хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 4

Бүгд: 16

75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Конвенц соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ж.Алдаржавхлан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Соёлын өвийн хэлтсийн дарга Б.Даваацэрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ж.Алдаржавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Д.Бум-Очир нарын тавьсан асуултад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёлын өвийн хэлтсийн дарга Б.Даваацэрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 13 цаг 50 минутаас хуралдааныг даргалав.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлээгүй болно.

Д.Цогтбаатар: Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	5
Бүгд:	16

68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, мөн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Ганбаатар, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Бат-Өлзий нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хаалттай горимоор хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 13
Бүгд: 17

23.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Х.Жангабыл, Р.Эрдэнэбүрэн, Э.Болормаа, Д.Ганбат, Л.Гантөмөр, Д.Бум-Очир нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Бат-Өлзий нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн, Д.Ганбат, Л.Гантөмөр нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17

70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 14 минут үргэлжилж, 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “ИХ ЗАСАГ” танхим
13 цаг 45 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны ирц бүрдсэн байна.

Жуковын Алдаржавхлан, Чинбаатарын Анар, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Нацагдоржийн Батсүмбэрэл, Энхбатын Болормаа, Дуламын Бум-Очир, Хажекберийн Жангабыл, Батбаярын Жаргалан, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Ганбатын Очирбат, Дамдины Цогтбаатар, Өлзийхүүгийн Шижир, Дашцэрэнгийн Д.Энхтүвшин, Равжихын Эрдэнэбүрэн нарын гишүүд хүрэлцэн ирснээр 5 сарын 27-ны өдрийн хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх 3 асуудал байгаа.

- Нэгдүгээрт, Конвенц соёрхон батлах тухай хуулийн төсөл.
- Хоёрдугаарт, Хэлэлцээр, соёрхон батлах тухай хуулийн төсөл.
- Гуравдугаарт, Улсын нисэхийн тухай хуулийн анхны хэлэлцүүлэг байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой горимын саналтай гишүүд байна уу?
Ч.Анар гишүүний микрофоныг өгье. Ч.Анар гишүүн.

Ч.Анар: Өдрийн мэнд эрхэм гишүүд ээ.

Улсын нисэхийн хуулийн ажлын хэсэг дээр төрийн байгууллагуудаас дахин хуулийн төсөл дээр санал ирсэн тул долоо хоногээр хойшлуулж өгөх горимын саналыг гаргаж байна.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ажлын хэсгийн ахлагч Ч.Анар гишүүн горимын санал гаргаж байна.

Тэгэхээр энэ асуудлыг хэлэлцэх асуудлаас хойшлуулъя гэсэн горимын саналаар санал хураалтыг явуулъя.

Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Ч.Анар гишүүний горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

75.0 хувиар дэмжигдлээ.

Ингээд энэ асуудлыг хэлэлцэх асуудлаас хаслаа.

Нэг.Конвенц соёрхон батлах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2026.04.30-ний өдөр өргөн мэдүүлсэн,
зөвшилцөх, хэлэлцүүлэх/

Хэлэлцэх асуудалдаа орцгооё. Нэгдүгээр асуудал. Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийг оруулаарай.

Уг хуулийн төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Жуковын Алдаржавхлан танилцуулна. Ж.Алдаржавхлан сайд.

Ж.Алдаржавхлан: Өдрийн мэнд хүргэе.

Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан соёлын байгууллагаас усан доорх соёлын өв хамгаалах тогтвортой алба хамгаалах зорилгоор 2001 онд Усан доорх соёлын өв хамгаалах конвенцыг батлан гаргасан.

Энэхүү конвенц нь 35 зүйл, дүрмээс бүрддэг бөгөөд конвенцын 1 дүгээр зүйл доод тал нь 100 жилийн турш, хэсэгчлэн эсвэл бүхэлдээ тодорхой хугацаанд туршиж эсвэл байнгын усан доор байсан соёл, түүх, эсвэл археологийн шинж чанартай хүний оролцоотой бүхий л ул мөрийг усан доорх соёлын өв гэж тодорхойлон түүнд археологи болон байгалийн орчинтой хамт байх дурсгалт газар, байгууламж, барилга, олдвор болон хүний биеийн үлдэгдэл, археологи болон байгалийн орчиндоо байгаа хөлөг онгоц, агаарын хөлөг, бусад төрлийн тээврийн хэрэгсэл, эсхүл тэдгээрийн аливаа тээврийн аливаа хэсэг, ачаа, эсвэл бусад зүйлс, эд зүйлс, эртний түүхэнд хамрах эд зүйлсийг хамруулахаар заасан байдаг.

Монгол Улсын хувьд далай тэнгист гарцгүй боловч нутаг дэвсгэрт орших том жижиг нуур, гол, усыг эртнээс дахин шүтэж ирсэн уламжлалтай бөгөөд түүнд холбогдох зан үйл дотор ембүү, алт мөнгөн сав, эд зүйлс өргөх явдал цөөнгүй байсан нь конвенцын 1 дүгээр зүйлд заасан усан доорх эд зүйлсийг хамаардаг.

Мөн Хөвсгөл зэрэг нуурт хуучны усан завь зэрэг зүйлс хадгалагдан үлдсэн байдаг бөгөөд эдгээр нь цаг хугацаа өнгөрөх тусам соёлын өвийн шинжийг олж үнэ цэнтэй болдог тул конвенцын тодорхойлолт заасан дотоодын усанд орох соёлын өвд хамаарна.

Манай улс усанд орох соёлын өвийг хамгаалах эрх зүйн тогтоол байхгүй улмаас эд зүйлсийг хулгайлах, эвдэхэн сүйтгэх явдал гарсаар байна. Тухайлбал, 2018 онд Завхан аймгийн Отгон сумд Отгонтэнгэр хайрханы бэлд орших Бадархундага нуурын оргилоос 366 мөнгөн аяга хулгайлсныг хууль сахиулах байгууллага илрүүлэн шалгасан.

Харамсалтай нь усанд орох соёлын өвийг хамгаалах эрх зүйн орчин байхгүй улмаас шүүх эдгээр зүйлсийг орон нутгийн засгийн захиргаанд шилжүүлж, мөнгөгийг ялган зах зээлийн үнээр худалдаж зарцуулсан байдаг ийм тохиолдол бүр үндэсний соёлын өв сан хөмрөгийн үнэт зүйл, байдлыг дордуулж өвийн оршин тогтнох чадвар устаж үгүй болох үр дагавартай юм.

Цаашид энэ мэт тохиолдлоос урьдчилан сэргийлэх, дурсгалт зүйлсийг конвенцын зорилгын үүднээс илрүүлж, бүртгэх, хадгалах, хамгаалах, өмчлөх, эзэмших, зохистойгоор ашиглах үйл ажиллагааны зохион байгуулалтыг боловсронгуй болгон түүнтэй холбогдох харилцааг эрх зүйн хүрээнд зохицуулах асуудал тулгамдаж байна.

Эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгоор усанд орох соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг сонирхон батлах тухай хуулийн төслийн боловсруулж хуульд заасан журмын дагуу өргөн барилаа.

Хэлэлцэн өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ж.Алдаржавхлан сайдад.

Ажлын хэсэг. Тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Балдангомьн Бат-Эрдэнэ, тус яамны Соёлын хэлтсийн дарга Бямбасүрэнгийн Даваацэрэн гэсэн бүрэлдэхүүнтэй орж байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Д.Бум-Очир гишүүнээр тасаллаа.

Д.Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Энэ конвенц. Манайхан зөвхөн яг өөрийнхөө юугаар бас бодоод байгаа юм. Манай газар нутагт усан доор байгаа эд агуурс буюу тэр нь дараа нь түүхийн ач холбогдолтой болж хувирах тухай. Цаг хугацааны эрхээр.

Гэтэл энэ дээр чинь олон улсын конвенц учраас жишээбэл гадаадын тэнгист манай түүхтэй холбоотой эд агуурс байж байгаа. Кюшү (Kyushu) арал дээр том орон нутгийнх нь музейд яваад ороход ер нь маш далайн усан онгоцны зангуу байдаг.

Тэгээд түүн дээр яах аргагүй Монгол гүрний усан цэргийн флотын зангуу гээд бүр бичигтэйгээ байж байгаа. Тэр нь Юань их гүрний үед явуулж байсан

флотоос үлдсэн зангууг дээшээ гаргаад тавьсан. Тэр нь түүхэн эд баримт болоод үлдсэн байж байх жишээтэй.

Тэгэхээр нэгэн цагт дундад зууны үед Монгол Улс зөвхөн энэ газар нутгаараа биш өөр газар манай түүхэн олон баримтууд хадгалагдаж байдаг. Одоо Иран, Ойрхи Дорнодыг яриад үзэх юм бол тэнд нуур, далай, тэнгисийн ёроолд манай түүхтэй холбоотой баримтууд байж байхыг үгүйсгэхгүй.

Тэр конвенцын дагуу хадгалагдана гэдэг бол бидний түүх хадгалагдаж байгаа гэсэн үг. Энэ утгаараа энэ конвенцод нэгдэх нь зөв өө. Би үүнийг дэмжиж байна.

Д.Цогтбаатар: Д.Цогтбаатар гишүүн үг хэллээ. Д.Бум-Очир гишүүний микрофоныг өгье.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Энэ маш чухал юм. Яах вэ, бид шууд далайтай улс орон биш. Сая Д.Цогтбаатар гишүүний яриан дээр их тодорхой гарлаа. Монголын соёлын өвийн асуудлууд зөвхөн Монголын хүрээнд биш дэлхийн түвшинд яригддаг. Тэр үүднээсээ маш чухал гэдгийг сая Д.Цогтбаатар гишүүн хэлж байна шүү дээ.

Түүнээс гадна энэ зөвхөн хилийн чанадад юм уу, Японд байгаа тэр соёлын өвийн зүйлсийг ярихаас гадна Монголд байдаг юм. Далайн юм уу, эсвэл нуурын усны түвшин нэмэгдсэнээс болоод тэр эргэн тойронд нь байсан юм уу, янз бүрийн археологийн дурсгалууд. Жишээ нь, Увс нуур юм уу, их нууруудын хотгорт усны түвшин өөрчлөгдөхөд эртний дурсгалууд хэсэгчлэн усанд автах юм уу, усны дээр доор орж гардаг ийм зүйлүүд байж байна.

Орхон гол, Сэлэнгэ мөрөн гэхэд түүхэн гүүр юм уу, усан тээвэртэй холбоотой зүйлс байж байх жишээтэй.

Хөвсгөл нуур орчимд гэхэд чулуун зэвсгийн болоод, хүрэл зэвсгийн үеийн янз бүрийн ул мөрүүд байх жишээтэй. Гэх мэтчилэнгийн олон талын ач холбогдолтой.

Ер нь усан доорх археологи гэдэг манай археологийн салбар сүүлийн үед маш сайн хөгжиж байгаа шүү гэдгийг би бүр онцгойлон дурдмаар байна.

Түүний нэг хэлбэр усан доорх археологийн асуудал ерөнхийдөө цаашдаа хөгжих. Ер нь олон улсад нэлээд их шинэлэг чиглэл. Монголд ч гэсэн шинжлэх ухааны чиглэл цаашаа хөгжих болов уу гэж би бодоод байна.

Яг соёлын яаман дээр соёлын өвийг хариуцсан мэргэжилтэн маань өөрөө археологийн мэргэжилтэн хүн байгаа. Б.Даваацэрэн дарга. Тэгээд би Б.Даваацэрэн даргаас онцгойлон мэдээлэл болгох үүднээс усан доорх археологийн асуудал онол, арга зүйн хувьд Монголд хэрхэн хөгжиж байгаа юм?

Ямар ямар дурсгалууд одоогоор олдсон байгаа юм? Сая бид Бадархундаганд өргөсөн мөнгөн аягануудын асуудлыг ярьж байна шүү дээ.

Гэх мэтчилэнгийн бусад мэргэжлийн археологичдын судалж байгаа ямар чухал олдворууд байгаа юм, ямар сайтууд байгаа юм? Энэ тал дээр мэдээлэл хүргээч гэж хүсэж байгаа юм.

Д.Цогтбаатар: Индэрийн микрофоныг өгье. Хэн хариулах вэ? Индэрийн микрофон өгье. Б.Даваацэрэн дарга индэр дээр очно уу.

Б.Даваацэрэн: Хурал даргалагч, эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Гишүүний асуултад хариулъя.

Монгол улсад одоогоор баттай тогтоогдсон усанд доорх соёлын өвийн бүртгэл байхгүй байгаа.

Гэхдээ урьдчилсан байдлаар Хөвсгөл нуур, Сэлэнгэ, томоохон нууруудын доор эд өлгийн зүйлсүүд байгаа гэдэг нь тодорхой мэдэгдэж байгаа.

Эдгээр зүйлсийг бид цаашид судалж, шинжлэх, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах, хадгалж хамгаалахын тулд мэргэжилтнүүдээ бэлтгээд эхэлсэн. Япон Улсад бид анхны шумбалтыг тун ойрын хугацаанд хийхээр бэлтгээд байгаа.

Цааш цаашдаа яг энэ чиглэлээр шат дараатай мэргэжилтнүүдээ бэлдэх, техник, тоног төхөөрөмжийн туслалцаа дэмжлэг авах, мөн олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх байдлаар үндэснийхээ чадавхыг бэхжүүлэхээр зорьж байгаа.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо хуулийн төсөв төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна.

Тэгвэл гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулж эхэлье.

Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

68.8 хувиар санал дэмжигдлээ. Санал явуулж дууслаа.

Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир гишүүн нэгдсэн хуралдаанд илтгэнэ.

Хоёрдугаар асуудалдаа оръё.

Хоёр.Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн,
соёрхон батлах/

Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлах асуудал байгаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хуралдаанд Гонгорын Дамдинням сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн, Чулууны Хишигдалай тус яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар холбогдох яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Гадаад харилцааны яамнаас Даваажавын Бат-Өлзий Гадаад яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хуралдаанд ирж оролцож байна.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням танилцуулна. Г.Дамдинням сайдын микрофоныг өгье.

Г.Дамдинням: Баярлалаа. Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.Путины Монгол Улсад 2024 оны 9 дүгээр сард хийсэн албан айлчлалын үеэр Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд Газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах тухай болон Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хэлэлцээрүүдийг байгуулсан.

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хэлэлцээрийн төсөлд нийлүүлэлтээс гадна татвар, хөрөнгө оруулалтыг тогтворжуулах заалтууд тусгагдсан.

Иймд олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлж, гишүүдээс ирүүлсэн саналын дагуу Оросын Холбооны Улсын талтай нэмэлт хэлэлцээ хийсэн.

Үүний үр дүнд хэлэлцээрийн үндсэн эх болон түүнд өөрчлөлт оруулах 6 зүйл бүхий протоколын төслийг эцэслэн тохиролцлоо.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 81 дүгээр захирамжаар олгосон эрхийн дагуу миний бие 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Москва хотноо

Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайд Сергей Евгеньевич Цивилевтой тус протоколд гарын үсэг зурсан болно.

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлснээр дараах ач холбогдолтой нөхцөлүүд бүрдэх юм.

Агаарын хөлгийн түлшний хангамж баталгаажиж, Чингис хаан олон улсын нисэх буудлын үйл ажиллагааны тасралтгүй үргэлжлэх нөхцөл бүрдэнэ.

Олон улсын стандартад нийцсэн түлшийг дундын зуучлагчгүйгээр зах зээлийн бодит үнээр шууд нийлүүлнэ.

Төрийн өмчит компаниуд хамтарсан компани байгуулж, нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийн үйл ажиллагааг хариуцан явуулна.

Дэлхийн геополитикийн нөхцөл байдал амаргүй байгаа энэ үед дээрх хоёр хэлэлцээ хамтдаа хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр манай улсын газрын тосны бүтээгдэхүүн, түлш, шатахууны нийт хангамжийн аюулгүй байдалд онцгой чухал үүрэг гүйцэтгэнэ.

Иймд агаарын тээврийн салбарын хөгжлийг дэмжих, шатахууны хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор боловсруулсан тус хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон батлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Г.Дамдинням сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Э.Болормаа гишүүнээр тасаллаа.

Д.Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

Д.Энхтүвшин: Газрын тос, нефть боловсруулах үйлдвэртэй холбоотой асуудлыг энэ хэлэлцээр дээр тусгах талаар өмнө нь мэдээлэл хүргэж байсан.

Энэ гэрээ хэлэлцээртээ ороогүй байгаа. Тэгэхээр үүнийг ямархуу байдлаар шийдэж байгаа талаар та нэг мэдээлэл өгөөч. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хэлэлцээр дээр “байгууламж” гээд өөрчилсөн байгаа. Тийм ээ. Гэсэн мөртлөө 5 дугаар зүйл дээр жишээлбэл “цогцолбор” гэдэг үгнүүд нь 4 дүгээр зүйл дээр нэг ширхэг. Энэ хэлэлцээрийн дотор нь зүгээр техник талаасаа харахаар “байгууламж” гээд өөрчилсөн мөртлөө 5, 6 газар үргэлжлээд “цогцолбор” гэсэн юм маань явж байна.

Тэгэхээр энэ нь энэ хэлэлцээр талаасаа яадаг юм? Хууль талаасаа харахад ойлгомжгүй харагдаад байна л даа. Энэ талаар нэг тайлбар хийж өгөөч? Баярлалаа.

Д.Цогтбаатар: Г.Дамдинням сайд хариулах уу? Г.Дамдинням сайдын микрофоныг өгье.

Г.Дамдинням: Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Газрын тосны үйлдвэрийн гарах бүтээгдэхүүн онгоцны түлшийг Монгол Улсын нэн тэргүүнд өөрөө худалдаж авахаар зохицуулалт хийгдсэн байгаа.

Бид Оросын Холбооны Улсын талтай бүр өмнө нь Г.Ёндон сайд хийсэн санамж бичиг байдаг. Одоо 6 дугаар сарын 03-аас 06-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсын Санктпетербург хотод Оросын Эдийн засгийн чуулганы үеэр Оросын Холбооны Улсын Роснефть компанитай бас санамж бичиг баталгаажуулж зурна.

Энэ хэлэлцээр соёрхон батлагдвал бид хамтарсан компаниа байгуулна. Энэ хамтарсан компанийнхаа дүрэм, гэрээнд энэ асуудлуудаа тогтооно гэдгээ санамж бичгүүдээр баталгаажуулсан байгаа.

Хоёрдугаар асуулт дээр гэрээ хэлцэлтэй холбоотой асуудлыг Гадаад хэргийн яамныхан хариулсан нь зөв байх аа? Тийм.

Д.Цогтбаатар: Индрийн микрофон өгье. Гадаад харилцааны яамны газрын дэд дарга байсан.

Индрийн микрофон өгье.

Д.Бат-Өлзий: Сайн байцгаана уу? Та бүгдийн асуултад хариулъя. Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Бат-Өлзий байна.

Гишүүний асуусан “цогцолбор” болон “байгууламж” гэж өөрчлөгдөж байгаа энэ асуудал дээр тодорхой хариултыг өгье.

2024 оны 9 сард Владимир Владимирович Путины Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр үндсэн хэлэлцээрийг байгуулахад нь Гадаад харилцааны яамнаас “цогцолбор” гэж орчуулсан.

Орос хэл дээрээс “комплекс” гэдэг үгийг тухайн үедээ “цогцолбор” гэж орчуулсан.

Гэрээг байгуулсны дараа 2025 оны 4 сард уг хэлэлцээрийг соёрхон батлуулах үүднээс холбогдох Байнгын хороогоор хэлэлцүүлэх үеэр зарим гишүүд яг энэ “цогцолбор” гэдэг үгийг Чингис хааны яг түлш цэнэглэх цогцолборыг хэлээд

байна уу, нэг бол нисэх буудлыг тэр чигээр нь дэд бүтцийг нь цогцолбороор нь нэрлээд байна уу гэдэг үл ойлголцох асуудал үүссэн.

Үүнээс үүдээд... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Индрийн микрофоныг гүйцээж хариулахад өгье.

Д.Бат-Өлзий: Хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг байгуулах, хэлэлцэх үеэрээ яг “агаарын хөлгийн түлш нийлүүлэх дэд бүтэц” нь юм. Үүнийг “байгууламж” гэж монгол хэл рүү орчуулъя гээд одоо протоколдоо “байгууламж” гэдгээрээ оруулсан байгаа.

Гэвч бид 2024 онд хоёр Ерөнхийлөгчийн байлцах үеэр холбогдох сайдуудын гарын үсэг зурсан хэлэлцээр дотор нь өөрчлөлт оруулж болохгүйн үүднээс протокол дээрээ шинэ орчуулгаараа буюу “байгууламж” гэж явж байгаа юм.

Тийм учраас цаашид үндсэн хэлэлцээр болон нэмэлт протокол, түүний хэрэгжилттэй холбоотой бүх ойлголтууд нь байгууламжаараа явна гэсэн үг. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Д.Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм. MOU (Memorandum of Understanding)¹ хэр хүчинтэй вэ гээд Г.Дамдинням сайдаас тодруулаад асууя.

Саяын юун дээр үндсэн гэрээ нь 4 дүгээр зүйлийн 1 дээрээ л “байгууламж” гэж байгаа болохоос бусад газар нь дандаа “цогцолбор” гээд явсан байгаа байхгүй юу. Уг нь хуулиар харвал хоёрдмол утгагүйгээр бүгдийг нь “цогцолбор” болгоод өөрчлөх ёстой байсныгаа бусдыг нь өөрчилж чадаагүй л явсан харагдаад байна.

Тэгэхээр энэ нэмэлтээр орсон ч гэсэн энэ чинь зөвхөн 4.1 дүгээр зүйлийг “байгууламж” гэж өөрчлөн найрууллаа гэсэн. Тэгэхэд 4.6 дээр, 5 дээр битүү “цогцолбор” гэж байгаа учраас жоохон үл ойлгогдох байдал үүсэж магадгүй харагдаад байна.

Би өөр нэг юм тодруулъя. Энэ “Эрчис Ойл” гэж компани чинь урдаас газрын тосны бүтээгдэхүүн оруулж ирэх чиглэлтэй компани шиг харагдаад байсан. Энэ ямар үндсэн үүрэгтэй компани талаар мэдээлэл өгөөч.

Д.Цогтбаатар: Г.Дамдинням сайдын микрофоныг өгье.

Г.Дамдинням: Нэгдүгээрт, бид компани байгуулах асуудлыг Монгол Улс өөрөө ямар нөхцөлд тавьж хийх нь бидний бүрэн эрхийн асуудал.

¹ Харилцан ойлголцлын санамж бичиг.

Тэгээд Оросын Холбооны Улстай үүнийг урьдчилаад хоёр ч санамж бичгээр баталгаажуулсан. Санамж бичгийнхээ хүрээнд л бид асуудлуудаа шийдээд явдаг.

Тэгэхээр энэ дээр санаа зовох асуудал гайгүй болов уу гэж бодож байна. Монгол Улсын эрх ашгийг зөрчсөн аливаа санал орж ирвэл бидний зүгээс татгалзана.

Хоёрдугаарт, “Эрчис Ойл”-той холбоотой асуудал дээр хуучин хувийн хэвшилд байхдаа онгоцны үнэ, тасалбарын үнэ хэт өндөр байгаад байгаа учраас төрийн өмчит аж ахуйн нэгж байгуулж шийдвэрлэсэн.

Энэ аж ахуйн нэгж бүх талаас л байж болох хямд эх үүсвэрээс онгоцны шатахуун авч авчирч нийлүүлдэг аж ахуйн нэгж. Хамгийн хямд үнээр л нийлүүлдэг. Хувийн хэвшлийнхнээс хямд үнээр л нийлүүлж байдаг. Дандаа.

Д.Цогтбаатар: Энэ давамгайлах хэл нь аль хэл байгаа билээ? Гадаад яам.

Д.Бат-Өлзий: Хэлэлцээрийг зохицуулснаар хэлэлцээрийг монгол, орос хоёр хэл дээр байгуулсан.

Хоёр хэл нь хоёулаа адил хүчинтэй байхаар заасан байгаа. Давамгайлах хэл байхгүй.

Д.Цогтбаатар: Наадах чинь тэгвэл наад томъёогоо жигдлэхгүй бол болохгүй шүү дээ.

Аль нэг хэл нь давамгайлж байгаа бол тэр хэл дээрээ ямар томъёотой байна түүгээрээ л явна. Наад дээрээ хоёр ижил хүчинтэй гэж байгаа бол монгол хэл дээрх томъёогоо та нар жигдлэх тухай бодохгүй болохгүй шүү.

Яагаад гэвэл хоёр өөр агуулгатай болж байна шүү дээ. “Reservation” гэж байдаг шүү дээ. Тэр механизмыг хэрэглэж болно.

Тэгээд бид үүнийгээ яг ингэж ойлгосон шүү гээд “reservation” хийж болно шүү дээ.

Наадах чинь агуулга өөрчлөхгүй, цэвэр техникийн асуудал учраас олон улсын хуулийнхаа хүрээнд хэлэлцээ хийж байгаа талтайгаа яриад л ойлголцох тухай асуудал.

Х.Жангабыл гишүүнд микрофон өгье.

Х.Жангабыл: Баярлалаа.

Агаарын хөлгийн түлш нийлүүлэх гэрээг байгуулах үйл явцад үнэтэй хувь нэмэр оруулсан, идэвх санаачилгатай ажилласан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, ажлын албаныханд гүн талархлыг илэрхийлье.

Надад хоёр асуулт байна. Бид өнөөдөр хоёр улсын Засгийн газрын хэмжээнд агаарын түлш нийлүүлэх гэрээг батлах гэж байна. Соёрхон батлах гэж байна. Агаарын хөлгийн түлш.

Та түрүүн дурдана лээ. Газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ ер нь байгаа юм уу? Энэ гэрээг соёрхон батлах уу? Нэг дэх асуулт.

Хоёрдугаарт, танилцуулга дээр агаарын хөлгийн түлшний үнийг “олон улсын зах зээлийн үнээр” гээд бичсэн байна.

Ер нь аль, ямар үнийг удирдлага болгож авах гэж байгаа юм бэ? Тусгайлан дахиад гэрээ хийх байх л даа. Ийм хоёр асуулт байна.

Д.Цогтбаатар: Индрийн микрофон өгье.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай.

Яг одоогоор Оросын Холбооны Улстай газрын тосны салбарт Газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх тухай хэлэлцээр. Мөн энэ дээр нь Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хэлэлцээрүүд соёрхон батлагдаад хүчин төгөлдөр болоод явна.

Яг газрын тосны талаар хэлэлцээр байхгүй. Цаашид энэ талаар судалж үзээд байгуулаад явах боломжтой. Шаардлагатай бол.

Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хэлэлцээр дээр Оросын Холбооны Улсын зах зээлийн үнээр нийлүүлнэ гэж байгаа. Оросынх биш шүү.

Ер нь зах зээлийн үнээр, ямар нэгэн дундын зуучлагчгүйгээр шууд нийлүүлнэ гэсэн үндсэн нөхцөл нь байгаа.

Д.Цогтбаатар: Болсон уу? Х.Жанганбыл гишүүн гүйцээж асууя.

Х.Жангабыл: Тэгэхээр газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байхгүй болохоор ер нь эрх зүйн хувьд ямар гэрээгээр зохицуулаад яваад байгаа юм бэ? Бид найдвартай, ийм үнээр гээд байнга ярьдаг шүү дээ.

Тэгэхээр эрх зүйн байгаа юм уу? Гэрээ ч юм уу, юу байдаг юм. Баримт бичиг. Нэг.

Хоёрдугаарт, сая үнэ тодорхой хэлбэл зүгээр байна. Яг тохирсон юм байгаа юм уу? Жишээлэхэд, Оросын дотоодын зах зээлийн үнээр юм уу, аль

эсвэл гадаадын зах зээлийн үнээр ч юм уу, Сингапурын биржийн үнээр ч юм уу, юу байдаг юм. Тийм ээ?

Д.Цогтбаатар: Г.Дамдинням сайд хариулъя. Г.Дамдинням сайдын микрофоныг өгье.

Г.Дамдинням: Нэгдүгээрт, манай улс Оросын Холбооны Улстай төр засгийн хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ ерөөсөө байхгүй явсан юм билээ. Аж ахуйн нэгжүүдийн хоорондын гэрээгээр л явдаг.

Тэгээд сүүлийн үеийн геополитикийн нөхцөл байдлын хүндрэлээс шалтгаалаад Засгийн газар хоорондын хэлэлцээр хийхгүй бол шууд хориг тавигдаад. Мэдэгдэхгүйгээр шууд хориг тавьдаг ийм эрсдэл бид нарт нүүрлээд байгаа. Бид чинь сар хүрэхгүй хугацааны нөөц хадгалж чаддаг.

Тэгэхээр Засгийн газрын хэлэлцээр хийсний бас нэг том давуу тал нь энэ гэнэтийн хориг саадуудад орохгүй байх ёстой тухай асуудал тавигдаж байгаа. Энэ гэрээгээ бид хийсэн. Ингээд соёрхон батлагдаад явна.

Хоёр дахь нь, үнийн хувьд бид бас зах зээлийн хамгийн хямд эх үүсвэрээс энэ компани өөрөө авах бүрэн эрхтэй тавьж байгаа.

Монголынхоо үйлдвэрээс ч авна, Сингапурын Platts-ийн (Warren C. Platts. 1909) үнээр авч болно, Хятадаас авч болно, Оросоос ч авч болно. Аль хямдаасаа бизнесийнхээ зарчмаар аваад явах тохиролцоотой. Тийм. Энэ хамтарч байгуулах компани нь. Тийм.

Д.Цогтбаатар: Р.Эрдэнэбүрэн гишүүний микрофоныг өгье.

Р.Эрдэнэбүрэн: Надад нэгдүгээрт нэг ийм санал байна.

Энэ асуудлаа Д.Цогтбаатар дарга аа, хаалттай горимд шилжүүлээд асуултаа асуумаар байх юм. Би яах вэ, юуг нь дэмжиж байгаа юм. Гэрээг нь.

Тэгэхдээ ойлголтоо сайн авч байж, ялангуяа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүд тэр тусмаа маш сайн ойлголтоо нэгтгэж байж ийм юм болж байгаа шүү гэж явахгүй бол ойлгомжгүй байгаа юмнууд нэлээн байна.

Одоо жишээлбэл бид энд монгол гэрээн дээрээ гэж хэлэх нь огт хамаагүй. “Байгууламж” гэнэ үү, “цогцолбор” гэнэ үү, юу ч гэнэ үү.

Бид нарын чинь гол санаа зовоод байгаа юм чинь тэр Оросын тал гэж бодож байгаа юм. Онгоцны буудлыг тэр чигээр нь гэж үзэж байгаа юм уу гээд ийм асуудлууд байгаа.

Тэгэхдээ үүнийг гэрээ хэлэлцээр явж байгаа үед ил бүгдээрээ микрофон дээр ярьцгаагаад байх нь нэг их тохиромжтой биш байх гэж бодож байна.

Тэгээд бүр нэлээн сайн ярьж ойлголтоо нэгтгэвэл чуулган дээр ч гэсэн гишүүд дэмжихэд, бид дэмжиж үг хэлж ярихад амар байхгүй юу.

Тийм учраас асуух асуултууд нэлээн олон байгаад байна л даа.

Д.Цогтбаатар: Тэгвэл гишүүн горимын санал гаргаж байна. Тэгвэл тэгээд та харин өөрийнхөө байр суурийг саналаараа л хэлэхээс. Би яагаад гэвэл гишүүн горимын санал гаргаж байхад би зогсоож чадахгүй шүү дээ.

Тийм л дээ. Гэхдээ гишүүн санал гаргаж байна л даа. Тийм.

Тэгэхээр би лав хаах эрхгүй байгаа юм. Байнгын хорооны зүгээс горимын санал гаргах эрх нь нээлттэй байна гэж байна.

Тэгэхээр би горимын санал хураалгая. Хуралдааныг хаалттай явуулъя гэсэн. Манайхан санал хураалтдаа бэлдээрэй.

Байнгын хорооны хуралдааныг хаалттай горимд шилжүүлбэ гэсэн саналыг дэмжбэ гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

23.5 хувиар санал дэмжигдсэнгүй.

Тийм учраас хурал нээлттэйгээрээ явна. Р.Эрдэнэбүрэн гишүүний микрофоныг өгбэ.

Р.Эрдэнэбүрэн: Би ийм л юм асуух гээд байгаа юм. Одоо энэ ч нэлээн тийм маргаантай яваад байх шиг байгаа юм. Одоо манай том онгоцнууд чинь хямдхан газраас түлшээ нөөцөлж авч ирж нисээд байдаг юм билээ шүү дээ.

Тэгээд одоо энэ ажлын хэсгийн өгч байгаа яриагаар тийм хямд зүйл байхгүй. Яг л зах зээлийн үнээрээ л явна гэсэн тийм санал хэлж байна шүү дээ. Тийм гэрээтэй гэж ярьж байна.

Тэгэхээр үр дүн нь яг болох юм бэ? Хямд биш байдаг. Зах зээлийнхээ үнээр байдаг. Тасралтгүй гэвэл бүгдээрээ ийш тийшээ яваад л тасралтгүй л аваад л байх л юм шиг байна шүү дээ.

Тэгээд сайдын хэлж байгаагаар... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Р.Эрдэнэбүрэн гишүүний микрофоныг гүйцээгээд өгбэ.

Р.Эрдэнэбүрэн: Нэн түрүүнд манай ашиглалтад орох үйлдвэрээс гарах онгоцны түлшийг хэрэглэнэ л гэсэн тийм юутай л гэж байна.

- Манайх хэдий хэмжээний гаргах юм?
- Тийм тооцоо нь байгаа юм уу?
- Хэдэн оноос гаргах юм?

- Үнэхээр асуудал байхгүй. Та нар өөрсдөө онгоцны түлштэй болсон учраас бид юм ярихгүй гэсэн тэр баталгаа нь байх юм?

Гээд иймэрхүү юмнуудыг жоохон гүнзгийрүүлээд асууя гэсэн. Тэгээд хаалттай ярихгүй гэж байх шиг байна. Зарим асуултуудаа болилоо.

Д.Цогтбаатар: Индрийн микрофон өгье.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай.

Зах зээлийн үнээр нийлүүлнэ гэж байгаа. Өнөөдөр бид “Роснефть Аеро” компанитай байгуулсан үнэ бол Оросын Холбооны Улсын дотоодын зах зээл дээр суурилсан үнээр авч байгаа.

Бусад олон улсын зах зээл дээр ер нь хоёр дахин өссөн байгаа. Өнөөдөр Хонгконгоос ч юм уу, Бээжингээс, Сөүлээс цэнэглэхэд 1800 орчим ам.доллараар онгоц цэнэглэгдэж явж байгаа.

Манай Чингис хаан нисэх онгоцны буудал дээрээс 1200 орчим ам.доллараар цэнэглэгдээд явж байгаа. Нэг тонн нь.

Өөрөөр хэлбэл 1200 орчим ам.доллар буюу 600 долларын доод тал нь зөрүүтэй байгаа. Одоо манай авиа компаниуд яаж байна вэ гэвэл өмнө нь бусад нисэх онгоцны буудлаас шатахуунаа ачиж хүрч ирээд Монголдоо буугаад буцаад нисэх рейсийнх нь шатахууныг ачиж ирдэг байсан бол одоо Монголоосоо full цэнэглээд очоод ямар нэгэн шатахуун худалдаж авахгүйгээр Монгол Улс руугаа нисэж ирдэг ийм нөхцөл байдалтай байгаа.

Олон улсын биржийн үнээр авч болно. Оросын Холбооны Улсын дотоодын үнээр авч болно. Бид цаашид хамтарсан компани байгуулахдаа мэдээж тодорхой хэмжээний хөнгөлөлтүүдийг ярилцаад явна.

Энэ хүрээнд санамж бичиг байгуулсан байгаа. Монгол Улсын баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэр жилдээ 80 орчим мянган тонн онгоцны түлш үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр баригдаж байгаа.

Өнөөдөр ашиглалтад ороод үйл ажиллагаа явуулж байгаа шинэ нисэх онгоцны буудал 140 мянган тонныг хэрэглэх боломжтой.

Цаашлаад шинэ нисэхийн өргөтгөлийн асуудал яригдаж байгаа. Гэх мэтчилэн судалгааг харахад Монголын дотоодын үйлдвэр нисэх онгоцны

буудлыг 100 хувь цэнэглээд явах боломжгүй. Тодорхой хувийг бид гадаад улсаас импортлох шаардлагатай болно.

Энэ дагуу Роснефть компанитай бид тодорхой санамж бичгийг байгуулаад нэн тэргүүнд боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг 100 хувь авч хэрэглэнэ. Илүү гарсан бүтээгдэхүүний 75 хувийг Роснефть компаниас авна. Үлдэж байгаа 25 хувийг аль нэг эх үүсвэрээс Монголын тал өөрөө шийдээд худалдаж авна гэсэн санамж бичиг байгаа.

Энэ санамж бичгийн хүрээнд хамтарсан компанийн гэрээ хийгдээд цаашаа явах болно.

2025 онд Монгол Улсын онгоцны түлшний хэрэглээ 85 мянган тонн болсон байгаа. Өөрөөр хэлбэл бидний барьж байгаа үйлдвэрийн үйлдвэрлэх бүтээгдэхүүнээс хэрэглээ аль хэзээний 5 мянган тонноор илүү гарсан явж байгаа. Цаашдаа ч өсөх хандлагатай байгаа.

Д.Цогтбаатар: Р.Эрдэнэбүрэн гишүүний микрофоныг өгье.

Р.Эрдэнэбүрэн: Яах вэ, гол санаа нь Г.Дамдинням сайд аа, миний бодоод байгаа юм нь дундын зуучлагчаа гаргаж байгаа юм байна гэж ойлгосон.

Тэгэхээр ийм л риск байгаа шүү. Би ийм л юм бодож байгаа. Дундын зуучлагчаа гаргаад төрийн өмчийн компани руу очиж байна. Дундын зуучлагч чинь уг нь бизнесийн хэлээр ярьдаг улсууд байгаа шүү. Одоо тэгээд бид төрийн л юм руу. Яах вэ, сонсоход гоё. Нөгөө махны ченж байхгүй болговол махны үнэ хямдарна, малчид шууд авчраад зардаг юм гэдэг шиг юм руу л яваад. Тэгээд тэр чинь буруу юм болж байгаа шүү дээ.

Тэгэхээр бид тэр бизнес хэлээр ярьдаг байсан юмнаас нь салгаад тэгээд яах вэ, мэдээж зуучлагч нь тодорхой хэмжээний юутай байх. Хэдэн хувиар буурах юм? Ингээд дундын зуучлагч гарахаар. Тийм тооцоо байдаг уу?

Тэгэхээр тэр юунаасаа гараад явж байгаа нь тэгээд л... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Индрийн микрофон өгье.

Ч.Хишигдалай: Саналыг хүлээж авлаа.

Үнийн талаар асуусан. 2012-2018 оны судалгаа байдаг. Тухайн үед бусад эйрпорт дээр шатахууны үнэ тонн нь мянга орчим доллар байхад манай улсад 1400-аас 1800 ам.доллар буюу 40-өөс 80 хувийн нэмэгдэлтэй зарагдаж байсан юм билээ.

Тэгэхээр “Эрчис Ойл” компани 2020 оноос хойш нисэхийн шатахууны нийлүүлэлтийг хариуцаад явж байгаа. Ямар ч байсан бусад эйрпортоос үнийн хөөрөгдөлтэй өндөр үнээр бүтээгдэхүүн нийлүүлэхгүй байгаа.

Ер нь сүүлийн үеийн нислэгийн тоо хэмжээ, зорчигчдын тоо хэмжээ зэргийг харахад нисэхийн салбарт нэлээдгүй хувь нэмрээ оруулж байгаа гэж үзэж байгаа. Цаашдаа энэ байдлаа хадгалаад явах боломжтой.

Д.Цогтбаатар: Э.Болормаа гишүүний микрофоныг өгье.

Э.Болормаа: Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хэлэлцээрийн асуудлыг дэмжиж байгаа.

Сүүлд гишүүн хэллээ. Энэ дундын зуучлагч нар үгүй болох. Гол зорилго нь төрөөс төр. Хамтарсан төрийн өмчит компани байгуулагдана гэж ойлгож байна.

Энэ асуудлыг би бусад салбаруудаас илүүтэйгээр төрөөс төр байх нь дундын зуучлагч үгүй болох нь зөв гэж харж байгаа.

Яагаад гэвэл бид 100 хувь импортын агаарын түлшээ нийлүүлж байгаа. Тэгээд бүгд бидний хойд хөршөөс төрийн өмчит компаниас худалдан авч байгаа.

Тэгэхээр энэ чөлөөт зах зээл яригдах салбар харамсалтай нь биш.

Ер нь шулуухан хэлэхэд картелийн шинж чанартай л зах зээл явагдаж ирж байсан. Энэ дундаас нь хүмүүс ашиг хүртээд. Тэр нь улс төрд нөлөөлж дамжиж орж ирдэг ийм зүйлийг үгүй болгох гэж байна гэж харж байгаа учир дэмжиж байна.

Үүнтэй холбоотой нэг зүйлийг тодруулъя. Өгсөн тоо статистик мэдээлэлд 2022 онд бид 38 мянган тонн агаарын түлш ашигласан бол өнгөрсөн 2025 онд 84 мянган тонн болоод ер нь хоёр дахин ихэссэн байна. 3 жилийн хугацаанд.

Цаашдын төлөвийг ярих юм бол өнгөрсөн 2024 онд 2.2 сая зорчигч тээвэр байсан бол 2028 онд 2.5 болж нэмэгдэх төлөвтэй байна гэсэн.

Тэгэхээр цаашдаа зөвхөн зорчигч тээвэр биш агаарын карго, бусад гэх мэтчилэн өнгөрсөн нэмэгдэж байгаа үзүүлэлтээ харах юм бол хадгалах сав, байгууламж хэр тусаж байгаа вэ?

Яг энэ хэлэлцээрт “байгууламж” гээд түрүүн бид хэлэлцээд байгаа энэ үг үсгийн өөрчлөлт дотор энэ “сав”, “байгууламж” нь орох уу?

Үүнтэй холбоотойгоор Г.Дамдинням сайд өмнөх агаарын түлш биш АИ-92. Тийм ээ. Дизель түлш, бусад шатахуунуудын савыг нэмэгдүүлнэ гээд Улсын Их Хурлаар бид дэмжих шийдвэрүүдийг гаргаж байсан юм. Энэ ажлын үйл явц хэр явцтай байна?

- Яг энэ агаарын түлштэй холбоотойгоор хэлэлцээрт энэ хэр явагдах вэ?
- Сав, байгууламжийн үйл ажиллагааг хариуцах нь хаана бууж байгаа вэ?
- Энэ хамтарсан компани дээр буух уу?

- Чингис хаан онгоцны буудал дээр буух уу?
- Өөр аж ахуйн нэгж дээр үү?
- Хэн хариуцах вэ?

Мөн одоогийн байдлаар Оросын Холбооны Улсын стандартын түлшний байгууламжтай бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсын стандартын Jet-A дээр ямар ч “байгууламж” байхгүй байгаа шүү дээ.

Цаашдаа үүнийг барих төлөвлөгөө бий юу?

Д.Цогтбаатар: Г.Дамдинням сайдын микрофоныг өгье.

Г.Дамдинням: Тийм. Зах зээлийн дараачийн өсөлттэй холбоотой онгоцны түлшний мэдээллийг Ч.Хишигдалай дарга өгнө.

Өнгөрсөн онд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэнээс бид нэлээн сайн үр дүн гаргасан.

Юу вэ гэхээр энэ анх удаагаа Их Хурал, Засгийн газраас сав суулганыхаа хүчин чадлыг нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд 21 аж ахуйн нэгжийн 25 агуулах буюу нийтдээ 298 мянган метр куб буюу Монгол Улсын нэг сарын хэрэглээний нөөц барих ажил эхэлсэн явж байна. Тийм.

Одоогийн байдлаар 21 аж ахуйн нэгжийн 9 нь гэрээгээ байгуулсан. Барилгын ажил эхэлсэн явж байна. 7 дугаар сарын 01-нд бүх аж ахуйн нэгжүүдийн гэрээг дахиж нэг дүгнэнэ.

Нийтдээ 187.7 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн хадгалах сав суулгыг нэг жилийн хугацаанд барьж дуусгах зорилготой бид ажиллаж байна. Нэлээн эрчимтэй шахаад явж байгаа.

Хоёрдугаар асуудал бол JET-тэй холбоотой асуудал. Энэ байгууламжийн гол онцлог юм байна лээ. JET гэдэг нь өөр гуравдагч зах зээлийн олон улсын стандарт. ТС (Топливо Самолётное) гэдэг нь орос стандарт.

Энэ хоёр түлш зөвхөн онгоцны далавчин дотроо холилдож болдог юм билээ. Онгоцны далавчин дотроо холилддог.

Манай Хөшгийн хөндийн Чингис хаан нисэх онгоцны буудлыг анх зээлээр барихдаа зөвхөн ганц байгууламжтай хийсэн юм билээ. Тэр “байгууламж” гээд байгаа нь “цэнэглэдэг систем”-ийг хэлээд байгаа юм. Зөвхөн “цэнэглэдэг систем”. Тэр ганцхан цэнэглэдэг систем нь дотроо хоёр төрлийн шатахуун холдож болдоггүй. Хоёр дахь эх үүсвэрийг нь бид өөрөөр хэлбэл JET-ээр цэнэглэдэг болох эх үүсвэрийг хийхэд 70 орчим сая доллароор хийх юм билээ.

Тэгээд хувийн хэвшлийнхэнтэй хамтраад хийе гэсэн шийдвэрийг гаргаад судалгааны ажилдаа ороод яриа хэлэлцээрээ хийгээд явж байна.

Нисэх онгоцны буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хийхэд 2 биш бүр 3 цэнэглэх байгууламжтай байхаар бид захиалгаа өгөөд байгаа. Аюулгүй байдал бодох талдаа тэгж явж байгаа.

Сав байгууламжийг энэ компани хариуцна. Өөрөө тусдаа аж ахуйн нэгж. Энэ сав, цэнэглэх “байгууламж” бүх юмаа өөрөө хариуцна. Зөвхөн шатахуунтай холбоотой. Ихэнх хэсгийг нь хамтраад хийгээд явах юм. Тэрийг нь нэмээд хариулчих.

Д.Цогтбаатар: Индрээс хариулъя.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай.

Оросын Холбооны Улсын “Роснефть Аэро” компани Монгол Улсын “Эрчис Ойл” хоёр компани хамтарсан компани байгуулна. Тус хамтарсан компани нь шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн байгууламжийг зөвхөн үйл ажиллагааг нь хариуцаж ажиллана.

Үндсэн байгууламжийн эзэмшигчээр төрийн өмчит “Эрчис Ойл” компани хэвээрээ байна.

Одоогоор байгаа шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн “байгууламж” нь зөвхөн нэг түлш цэнэглэх гидрант системтэй. Яг энэ 2026 онд бид бусад эх үүсвэрээр буюу бусад улсад хэрэглэж байгаа Jet-A төрлийн түлшийг хэрэглэх тусдаа системийг бүрдүүлэх гээд зураг төслийн ажлыг хийлгэж байна.

Тендерийн сонгон шалгаруулалт нь дууссан. Аж ахуйн нэгжтэй гэрээгээ байгуулаад явж байна. Энэ оны 9 сар гэхэд зураг зурагдаад дуусна.

Ер нь Jet түлшинд зориулсан тусдаа... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Э.Болормаа гишүүний микрофоныг өгье.

Э.Болормаа: Мэдээллийн шинж чанартай яг хоёр асуулт тодруулж асууя.

Энэ хэлэлцээр дээр Монголын талаас “Эрчис Ойл” Оросын талаас “Роснефть” гэсэн хоёр компани байгаа.

Яг одоогоор Монгол Улсад агаарын түлш нийлүүлэхэд хувийн хэвшлээр буюу дундын зуучаар явахдаа цаад талд Роснефтиэс өөр газраас худалдаж авдаг зүйл бий юу? Эсвэл эх үүсвэр нь зөвхөн угаасаа Роснефть үү гэдгийг тодруулъя.

Тэгээд сая бид гуравдагч тал гээд байгаа. Яг ямар хувийн хэвшлийн компаниуд энэ хүртэл агаарын түлш Монгол Улсад нийлүүлж байсан бэ? Дотоодын аж ахуйн нэгжүүд.

Тэгэхээр ямар аж ахуйн нэгжүүдэд энэ хэлэлцээр нөлөөлөх вэ гэдгийг тодруулъя.

Д.Цогтбаатар: Индрээс хариулах уу? Индрийн микрофон өгье.

Ч.Хишигдалай: Үйлдвэрлэгч улсын хувьд хэд хэдэн компаниуд онгоцны түлш үйлдвэрлэж байгаа. Роснефть, Газпром, ТАНЭКО, ер нь боломжит үйлдвэрүүд үйлдвэрлэж байгаа.

Манай аж ахуйн нэгжүүд аль хямд нийлүүлж байгаагаас нь худалдаж аваад явж байгаа.

“Эрчис ойл” компанийн хувьд яг өнөөдөр зөвхөн Роснефть компани гэхгүй. Хямд үнийн саналтай компаниудаас, Газпромоос нь ч, Татнефтээс нь ч аваад явж байгаа.

Нийлүүлэлтийн хувьд –

- “Шунхлай”,
- “Сод Монгол”,
- “Мэргэ ван”,
- “Магнай трейд”,

гээд бүх боломжит компаниуд нийлүүлж ирсэн. Яг өнөөдөр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь “Сод Монгол” компани байгаа.

Бүх нийлүүлэгч компанийн хувьд нөгөө байгууламжийнхаа ашиглалтын зардлыг төлөөд бүтээгдэхүүнээ нийлүүлээд явах боломж нь нээлттэй байгаа. Үүнийгээ ашиглаад явж байгаа.

Д.Цогтбаатар: Э.Болормаа гишүүнд тодруулга өгье.

Э.Болормаа: Тэгэхээр яг одоогоор идэвхтэй зөвхөн “Сод Монгол” компани нийлүүлж байгаа гэж ойлголоо.

Өнгөрсөн 20 жилийн хугацаан дахь яг аль аль компаниуд ямар хэмжээгээр энэ зах зээлийнхээ хэдэн хувийг эзэлж байсан юм? Энэ мэдээллийг дараа нь албан бичгээр хүргүүлэхийг хүсье.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Бид ингээд сонсоход их сайхан сайхан юм яриад байгаа юм. Ингээд л аягүй хямдхан юм насаараа авч байх юм шиг. Тэгээд л бид хэд л хийлээ гээд байдаг.

Тэгээд тодорхой хугацаа өнгөрсний дараа яг түрүүний яриад байсан шиг л юм болж байгаа юм л даа. Бусад газрууд дэлхийн зах зээлийн үнээр онгоцны түлшийг мянган доллароор авдаг байсан бол манайх л болохоор 1600, 1700-гаар авдаг байх жишээтэй. Тийм байсан гэж саяын хүн хариулж л байна шүү дээ.

Тэгээд манайд ганцхан л юм алга. Хариуцлага гэдэг юм чинь алга. Тэр онгоцны буудал гэж байна. Олон улсын онгоцны буудлыг маш үнэтэй барьсан гээд байгаа. Зээлийн хөрөнгөөр. Гэтэл хар л даа. Яг тэр тоног төхөөрөмж нь шаардлага бас хангахгүй л юм байгаа байхгүй. Ахиад л хийнэ гээд л. 70 сая доллар хэрэгтэй л гэж байна.

Тэгээд ийм байгаа. Хэрвээ зах зээлийнхээ үнээр.

→ Одоо ямар үнээр? Гэрээ хэлэлцээр байхгүй л аваад байгаа шүү дээ.

→ Тэгээд болж л байгаа юм чинь тэгээд аваад байж болдоггүй юм уу?

→ Заавал тэгж гэрээ хэлэлцээр хийх шаардлага байдаг юм уу?

→ Тэгээд энэ Улсын Их Хурлаар батлуулах хэрэг байгаа юм уу?

Тэгээд ингэдэг л дээ. Манайхан. Өөрсдөө хоёр хөршийнхөө хүмүүс рүү гүйж очоод янз бүрийн юм ярьж байгаад янз бүрийн гэрээ хийдэг. Тэгээд эргээд дараа нь гэрээгээ биелүүлдэггүй.

Тэгээд тэрний цаана заавал нэг муу муухай юм байж байдаг. Жишээлбэл,

→ саяын энэ гэрээ чинь тэгээд маргаан гарвал хаана хандах юм?

→ Ямар улсын шүүхэд хандах юм?

→ Ямар улсын арбитра хандах юм?

→ Тэр чинь байгаа юу?

→ Тэр Беларусын арбитраа өөрчилсөн үү? Тийм.

→ Тэр хоёр ямар ялгаа байгаа юм?

Ямар ч ялгаа байхгүй шүү дээ. Гэх мэтчилэнгийн.

→ Тэгээд үүнийгээ олон улсын гэрээ гэх юм уу?

→ Тэгээд Улсын Их Хурлаар үүнийг соёрхон батална гэх юм уу?

Иймэрхүү тоглоомтой юмнуудаа больмоор байгаа юм.

Тэр Харбины гэрээг баталлаа л гэсэн. Соёрхлоо, батлууллаа л гэсэн.

Тэгээд тухайн үедээ үнэ нь байхгүй гэсэн. Үнийг нь хийсэн л байсан юм билээ шүү дээ. Тэгээд л тэрийгээ нууж хааж ярина. Ямар хэрэгтэй юм.

Бидний давуу тал чинь харин Улсын Их Хурал дээрээ ил ярьдаг, хэлэлцдэг, үүнийг нь хэлдэг байх чинь та нарт хэрэгтэй байхгүй даа. Энэ улс оронд хэрэгтэй. Ийм л юм байгаа юм.

Энэ бол шаардлагагүй зүйл л гэж бодоод байх юм. Хийдэг бол компани хоорондоо хийгээд л явдаг л юм байгаа биз. Заавал Засгийн газар нь оруулж ирээд л, Улсын Их Хурал нь соёрхон батлаад л.

Одоо дайнтай л байгаа шүү дээ. Форс-мажорын (Force Majeure)² гэж асуудал байдаг.

- Хэрвээ тэр гэрээгээ биелүүлэхгүй яах юм?
- Зах зээлийн үнээр байх юм бол арван хэдэн жилээр хийж яах юм?
- Ямар ч утгагүй юм байна шүү дээ. Наад заалтууд чинь. Энэ гэрээгээ хийж хийсэн хийгээгүй тэгээд бага үнээр авч чадаад байгаа юм бол аваад л явъя л даа. Угаасаа хоригтой л байгаа шүү дээ.

Тэгээд ганцхан орноос... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Г.Дамдинням сайдын микрофоныг өгье.

Г.Дамдинням: Д.Ганбат гишүүн ээ, Монгол Улс маань хоёрхон хөрштэй. Тэгээд өөр хаанаас ч оруулж ирэх юм. Би сайн мэдэхгүй л байна. Тийм.

97 хувийг нь Оросын Холбооны Улсаас авч байгаа. Тэгээд урд хөршөөсөө бид авах боомтуудаа нэмж байгаа.

- › Урд хөрш маань үргэлжийн дутагдалтай байдаг.
- › Резкспорт их төвөгтэй байдаг.
- › Үнэ нэмэгддэг.
- › Тээврийн өртөг нэмэгддэг.

Байгаа боломж маань л энэ. Манай нэ оршин байгаа нөхцөл маань л энэ.

Хоёрдугаарт, гэрээ хийхгүй бол дэлхий нийтийн нөхцөл байдал тайван бус байна. Засгийн газар хоорондын хэлэлцээр хийхгүй бол байсхийгээд хаагдаад байна. Нийлүүлэлт хийгдэхгүй байна.

Үнэнийг хэлэхэд сүүлийн хэдэн жил энэ шатахуун бид 100 хувь хараат.

Хоёрдугаарт, тэсрэх бодис 100 хувь хараат нийлүүлдэг.

² Давагдашгүй хүчин зүйл.

Эндээсээ бид энэ үйлдвэрээ бариад дуусаад бас нэг дотоодынхоо хэрэглээний 50 орчим хувийг хангадаг болтлоо өөр боломж алга.

Бидний хувьд Засгийн газар хоорондын хэлэлцээр хийхгүй бол бид цаашдаа танайд тогтвортой нийлүүлж чадахгүй шүү гэдэг шууд тийм байр суурийг авдаг.

Одоо ний нуугүй хэлэхэд гуйж түүгээд л явж байгаа. Оросын Холбооны Улс маань биднийг сайн хөршийнхөө хүрээнд үнэхээр хүнд нөхцөлүүдэд өөрсдийнхөө дотоодын хомсдолыг үл тоон бид нарт 100 хувь нийлүүлээд л явж байгаа. Талархалтай хандах ёстой байх гэж бодож байна.

Зүгээр улсынхаа эрх ашгийн үүднээс хэлж байна шүү. Г.Дамдиннямын үүднээс биш.

Хоёрдугаарт, үнэтэй байсан тухай манай газрын даргын хэлсэн мэдээлэл төрийн өмчийн компани байхаас өмнөх үеийн асуудал. Хувийн аж ахуйн нэгж авч явж байх үеийн асуудал.

Та санаж байгаа бол бид 2022 оны парламентад сууж байгаад “Мэргэ Ван” гэдэг компани зах зээлийн үнээс 40 хувь илүү нийлүүлж байгаа асуудал яригдаж байж бид энэ төрийн өмчит компанийг бүгдээрээ ярьж байгаад байгуулж байсан. Шийдвэр гарч байсан. Тухайн үед.

Маргаантай холбоотой асуудал. Анх ирсэн төсөл нь, өнгөрсөн оны хавар орж ирсэн төсөл нь. Ц.Туваан садын үед орж ирж байсан төсөл бол Оросын Холбооны Улсын арбитраар байсан. Тэр үед бас нэлээн шүүмж дагуулсан.

Ингээд бид ярилцаж байгаад Оросын Холбооны Улсад Казахстан, эсвэл Беларусь гэсэн санал тавьсан. Гадаад хэргийн яамнаас тодруулсан. Тусгаар тогтносон найрамдалт харилцаатай улс учраас Беларусын саналаар явъя гэдэг ийм шийдэлтэй л байгаа.

Би Оросын Холбоо Улс, бүхэл бүтэн тусгаар тогтносон улсыг ямар ялгаа байгаа юм гэж хэлж чадахгүй байна. Тийм. Парламентын индэр дээрээс. Тийм. Ийм л байна.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Яах вэ, тэр Казахстангаас авч болохгүй юу. Сав суулгаа яагаад бэлдээгүй юм? Сав суулгаа бэлдсэн байсан бол тэр чинь үнэ бага үед нь.

Сая урд талын улсыг гээд ярьлаа. Тийм ээ. Хөрш орноо. Тэнд чинь 10 жилийн нөөцтэй шүү дээ. Түлш бензинээ. Япон чинь бүр 10 жилээр нөөцөлж байгаа шүү дээ.

Тийм сайн үлгэр жишээг ав л даа. Тэгээд нэг компаниас, нэг орноос. Ийм хараат ийм зүйл хийчхээд дараа нь тэгээд бид хямдхан авч чадлаа гэж байгаад асуудал гардаг.

- Тэр дээр яг өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалж чадах уу?
- Чадна гэж бодож байна уу?
- Беларусьт бол?

Д.Цогтбаатар: Г.Дамдинням сайдын микрофоныг өгье.

Г.Дамдинням: Д.Ганбат гишүүн ээ, би сайдын ажил хийгээд жил хүрээгүй байна. Энэ хугацаанд ямар ч байсан тусгайлсан хууль гаргуулаад нөөцийн саваа хийх Монгол Улсын хувьд анхны бодлого гаргаад, дотаци өгөөд аж ахуйн нэгжүүдээр саваа нэмүүлээд явж байгаа. Өмнөхийг сайн мэдэхгүй юм. Оролдлогууд байсан юм билээ. Хөөрхий.

Манай хэрэглээ чинь их огцом өсөөд байна л даа. Тэгээд уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрчимжээд явж байгаа учраас энэ хэрэглээ их огцом өсчхөөд байгаа юм.

Тэгээд ямар ч байсан 3 сарын нөөцөө хадгалдаг савтай болох бодлогыг 2028 он болтол хэрэгжүүлнэ. Та бүгдийн маань дэмжлэг их орж байгаад их баярлаж байгаа.

Казахстан Улсаас авах тухай асуудал яригдаж байна. Тээвэртэй холбоотой асуудал нь туйлын хүнд байдаг юм. Их хүнд байдаг юм. Оросоор дамжуулж авдаг. Ганц нэг удаа авч байсан тохиолдол бий. Тэгэхдээ Казахстан улс дотооддоо хомсдолтой. Экспортлохгүй байгаа.

Д.Цогтбаатар: Л.Гантөмөр гишүүний микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Ер нь ярилцлага тийм алдаатай яваад байгаа юм.

Энэ агаарын хөлгийн түлшний гэрээ гэдэг бол тусдаа зүйл ерөөсөө биш байгаа. Энэ яасан бэ гэхээр бид Оросын Холбооны Улсаас бензин, дизель түлшээ тогтвортой авъя гэдэг гэрээ хийе гэдэг саналыг бид тавьдаг юм. Манай Засгийн газар.

Тэгэхээр “окэй”. Үүнийг чинь хийе. Тэгээд зөрүүлээд Оросын тал яадаг вэ гэхлээр зэрэг тэгвэл энэ агаарын хөлгийн түлшийг чинь 100 хувь бид хангадаг болмоор байна гэдэг юм.

Тэгээд энэ гэрээ хийх юм бол та нартай бид бензин, түлшний гэрээ хийе гэдэг юм. Д.Ганбат гишүүн ээ. Ерөөсөө түүх нь ийм.

Тэгээд хоёр гэрээн дээр Оросын Ерөнхийлөгч ирэх үеэр зурдаг юм. Нэг нь энэ санамж. Нөгөөдөх нь болохоор энэ гэрээ байгуулагдсан тохиолдолд хүчин

төгөлдөр болно гэсэн бензин, дизель түлшний гэрээ байгаа. Тийм биз. Г.Дамдинням аа?

Г.Дамдинням: Тийм.

Л.Гантөмөр: Энэ дотор дахиад асуудал байдаг юм.

- ➔ Эгийн голын цахилгаан станцыг бид ярьж гэдэг юм.
- ➔ Улаанбаатар хотод байгаа Оросын Холбооны Улсын өмчийг буцааж өгье гэдэг ярианууд байдаг юм.
- ➔ Төмөр замын шинэчлэл пакежаараа энэ яриан дотор байдаг юм.

Тэгэхээр энэ болгоныг Гадаад яам арай жоохон ой санамжтайгаараа энэ Аюулгүйн байнгын хороон дээр орж ирж асуудлаа ярьдаг баймаар байна. Энэ чинь хоёр улсын хоорондын харилцааны асуудал.

Гадаад яам, Аж үйлдвэрийн сайд руу өшиглөж болдоггүй ийм ярианууд байгаад байгаа юм. Жишээлбэл, бид яг үүнтэй уялдуулаад –

- “Төмөр зам”,
- “Эгийн гол”

-гэдэг хоёр зүйлээ өнөөдөр яриад нэлээн урагшлуулсан байх учиртай юм.

Тэгээд тэрийг Гадаад яам хийж байна уу, үгүй юу? Мөн үүнтэй уялдуулаад бид “хийн хоолойн төсөл” гэдэг зүйл яг аль түвшинд явна гэдэг ийм мэдээлэлтэй байх ёстой.

Тэгээд зүгээр Г.Дамдинням сайдад анхааруулж хэлэхэд тэр “байгууламж” гэдэг зүйлээ яг нэгмөр болгож Их Хурлаар оруулахгүй бол. Энэ чинь Их Хурлаар нэг удаа ороод унасан юм. Их Хурал эсэргүүцсэн юм.

Тэгээд энэ Оросын талын санал, шахалт гэдгийг бид ойлгож хүлээж авахгүй бол Г.Дамдинням буруу ярьж байна. Бид их гавьяа байгуулах гэж байна гэж худлаа ярьж ерөөсөө болохгүй шүү.

Нөгөө талдаа тэр нисэх буудал дээр ерөөсөө өмч өгч болохгүй.

Яагаад гэвэл Оросын Холбооны Улстай яриа хэлэлцээр хийхээр нэг ийм өмчийн хэрүүл рүү ороод байдаг юм.

- Сургуулийн газар,
- Ленинг клуб,
- Төмөр замын газар гэдэг нэг аймаар том сэдэвтэй.

Бид ерөөсөө юм ярьж болдоггүй. Урдаас энэ төмөр замын газраа бид авмаар байна. Тэгээд яваандаа нисэх буудал дотор Оросын Холбооны Улс өөрийн гэсэн газартай болно гэдэг ийм асуудал яригддаг болох вий. Тийм учраас... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Л.Гантөмөр гишүүнд 1 минут гүйцээгээд өгье.

Л.Гантөмөр: Тэгээд би гол тодруулж байгаа юм бол манай баялгийн сайд гэрээг хамгаалж түлхэх гэхээсээ илүүтэйгээр энэ хоёр улсын харилцааны асуудал гэдгийг их тодорхой хэлээд. Өмч бол бид өгмөөргүй байна гэдгийг Оросын тал шулуухан хэлмээр байна.

Яагаад гэвэл өмч гэдэг чинь хоёр улсын харилцаанд яг сэв болоод байдаг эд байлаа л даа. Болдоггүй. Зарим засгийн үед хаягддаг. Тийм зүйл байгаад байгаа юм.

Тийм учраас би зүгээр Байнгын хороо яг энэ хэлэлцээрийг Их Хурлаар соёрхон батлах үеэр Оросын Холбооны Улстай хийж байгаа сүүлийн 10 жилийн гэрээ хэлэлцээрийг нэг сонсмоор байх юм.

Уг нь Г.Тэмүүлэн дарга байвал үүнийг хэлье гэж бодож байгаа юм. Тэр Гадаад хэргийн сайд нь ирээд деталь бүх юмаа Байнгын хороондоо яримаар байна. Ингэж байж хоёр улсын харилцаа бүтэн харагдана. Тэгэхгүй бол энэ Д.Ганбат гишүүний хэлж байгаа үнэн шүү дээ.

Д.Цогтбаатар: Яах вэ, гүйцээж хэлэх боломж бий.

Ингээд гишүүд асуулт асууж. Индэрийн микрофон өгье. Г.Дамдинням сайд хариулъя. Тэгээд дараа нь индэрийн микрофон өгье. Г.Дамдинням сайд өөрөө шийд.

Г.Дамдинням: Өмчлөлтэй холбоотой, гэрээтэй холбоотой мэдээллийг яг тодорхой манай газрын дарга өгнө.

Л.Гантөмөр сайдад маш их баярлалаа. Миний хэлж чадахгүй байгаа юмнуудыг л ярьж байна.

Тэгээд Гадаад хэргийн яамнаас л ер нь яг энэ гадаад харилцаатай холбоотой асуудал дээр зөвлөгөө авч бид хөдөлж байгаа. Тэр “байгууламж” болон тэр үгтэй холбоотой асуудлуудыг нэгтгэх асуудлыг Гадаад хэргийн яамтайгаа ярилцъя. Тийм. Баярлалаа. Танд.

Д.Цогтбаатар: Д.Бум-Очир гишүүний микрофоныг өгье. Индрийн микрофон. Өмчтэй холбоотой.

Ч.Хишигдалай: Шинэ нисэх онгоцны шатахуун хангамжийн байгууламж зөвхөн төрийн өмчит “Эрчис Ойл” компанийн нэр дээр байна.

Хамтарсан компани бол зөвхөн үйл ажиллагааг хариуцна. Байгууламжаар дамжуулж бүтээгдэхүүн нийлүүлэх асуудлыг дамжуулна. Ямар нэгэн өмчлөлийн асуудал байхгүй. Үүн дээр хоёр талаас харилцан ойлголцлын санамж бичиг байгаа. Мөн хэлэлцээр дээр дурдагдсан өмчлөлийн асуудал ерөөсөө дурдагдаагүй байгаа. Байгууламжийн талаар.

Хэлэлцээрт оруулдаг нэмэлт протокол дээр байгууламжийн асуудлыг бид яг өмнөх Улсын Их Хурлын Байнгын хорооны хуралдаанаар өгсөн үүргийн дагуу агаарын хөлгийг түлшээр цэнэглэх дэд бүтцийг гээд хаалтад цаашид “байгууламж” гэх, удирдах болон ашиглах хамтарсан компани байгуулна гээд тодорхой заасан байгаа. Тийм.

Тэгэхээр гол бидний байгуулсан протокол... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Д.Бум-Очир гишүүнд микрофон өгье.

Д.Бум-Очир: Миний асуух гэж байсан нэлээд асуултуудыг гишүүд маань асуулаа. Жишээ нь, ер нь нэг эх үүсвэр эх үүсвэрээс хараат байх тухай асуудлыг гишүүд ярьж байна. Мөн яг Казакстаны асуудлыг асууя гэж байсан. Асуулаа.

Ер нь цаашдаа энэ эх үүсвэрээ олон болгох тал дээр бид анхаармаар байна. Улсынхаа аюулгүй байдлыг ч бодсон, тусгаар тогтнолоо ч бодсон гээд олон зүйлийг бодвол.

Тэгээд энэ дээр түрүүн сайд өөрийнхөө байр суурийг илэрхийлж байх шиг байна. Ер нь хүнд байдалтай байдаг гэдгийг хэлж байна.

Бас гишүүд маань асуугаагүй, тэгэхдээ олон нийт сонирхож байж болзошгүй нэгэн зүйлийг тодруулах гэсэн юм. Тэр нь вэ гэхээр энэ онгоцны билетийн үнэд яаж нөлөөлөх вэ? Бид урьд нь зөндөө ярьдаг байсан. Монголд онгоцны билетийн үнэ харьцангуй өндөр байгаа нь түлштэйгээ холбоотой байна гэдэг санал шүүмж зөндөө явж байсан.

Тэгэхээр одоо энэ хийх гэж байгаа гэрээний үр дүнд онгоцны билетийн үнэд хэрхэн нөлөөлөх бол оо? Өсөх юм уу, буурах юм уу? Ямар нөхцөл байдал бий болох гэдгийг олон нийтдээ мэдээлэл хүргэвэл сайн байна.

Д.Цогтбаатар: Индрийн микрофон өгье.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай.

2020 оноос хойш “Эрчис Ойл” компани үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Үүнтэй холбоотой агаарын хөлгийн түлшний үнэ тодорхой хэмжээгээр буурсаны үр дүнд манай улсын зорчигч тээврийн нислэгийн тоо болон зорчигчдын тоо нэмэгдсэн.

Ер нь дундаж нислэгийн 36-аас 80 хувь нь шатахууны зардал байдаг. Үүнийг тодорхой хэмжээгээр бууруулаад явж байгаа. Яг өнөөдөр дэлхийн бусад улс оронд шатахууны үнэ хоёроос гурав дахин өссөн байна. Fuel Surcharge (Шатахууны нэмэгдэл төлбөр) буюу онцгой байдал зарлаад маш олон авиа компаниуд дампуурч байна.

Манай улсын хувьд харьцангуй хямд үнээр бүтээгдэхүүн худалдаж авч байгаа учраас олон улсын нислэг дээр асуудал бага байна. Гэхдээ мэдээж энэ олон улсын хямралт нөхцөл байдалтай холбоотой үнийн өсөлт бага хэмжээгээр бид нарт нөлөөлж байна.

Яагаад гэвэл Оросын Холбооны Улсын дотоодын үнэ тодорхой хэмжээгээр эрэлттэй холбоотой өсөөд байгаа. Үүнтэй холбоотой манайд нэг бага хэмжээний өсөлт мэдэгдэж байгаа. Гэхдээ бусад улс орон шиг хоёроос гурав дахин өсөөгүй байгаа.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Д.Ганбат гишүүнээр тасаллаа.

Р.Эрдэнэбүрэн гишүүний микрофоныг өгье.

Р.Эрдэнэбүрэн: Хоёр, гуравхан санал хэлэх гэсэн юм.

Нэгдүгээрт, энэ гэрээг дэмжиж байгаа. Мэдээж дэлхийн нөхцөл байдал хүнд байгаа үед нефтээр таслахгүй явж байгаад Оросын Холбооны Улсад талархалтай байдаг. Тэрийгээ илэрхийлж байх ёстой байх гэж бодож байгаа.

Хоёрт, хэд хэдэн удаа Байнгын хороон дээрээ ялангуяа Оросын Холбооны Улс, өөр улсуудтай холбоотой ч гэсэн гэрээнүүд орж ирэхдээ дээд түвшинд тохирсон учраас явуулахаас өөр аргагүй байна гэж хэлэлцээрүүд их орж ирж байна.

Хэрэв энэ хэлэлцээрүүдээс өмнө Их Рурал дээр яригдаад, тодорхой хайрцаг заагаад өгсөн байдаг бол тэрийгээ эхлээд танилцуулж баймаар байна.

Цаашдаа энэ Их Хурлаасаа чиглэл авч байж тэр ярианууд яригдаж явж байхгүй бол дээд хэмжээндээ тохирдог. Тэгээд Их Хурал дээр ирээд маргаан үүсээд явдаггүй. Тэгээд нөгөө талдаа худлаа хэлсэн, хэлсэн амандаа байдаггүй ийм байдал руу орох гээд байгаа байдал ажиглагдаж байна.

Тийм учраас манай Байнгын хороо, ялангуяа Засгийн газарт энэ чиглэлээр нэлээн сайн ярьж хэлж, чиглэл өгч байх ёстой Байнгын хороо гэж бодож байгаа. Энэ дээрээ цаашдаа анхаарах хэрэгтэй байна.

Гуравт, ялангуяа Оросын Холбооны Улстай гэрээ хэлэлцээр хийхдээ миний бодол бол бид нарын нөгөө уламжлалт харилцаанаас ч болдог юм уу, маш олон хүмүүс тэнд очиж Оросын Холбооны Улсад сурч байсан энэ тэрээс болдог юм уу төр хоорондоо харилцахаасаа илүү хувийн хэвшлийнхэн маань очиж гэрээ хэлэлцээр хийх юм бол илүү үр дүнтэй байгаад байна. Ийм кэйсүүд ч байна.

Тийм учраас цаашдаа ялангуяа хойд хөршдөө энэ deal-үүдийг эхлээд хувийн хэвшлийнхнийгээ явуулж яриулдаг, гэрээ хэлэлцээр хийлгэдэг энэ чиглэл рүү бодлогоо жоохон баривал Засгийн газар илүү үр дүнтэй байх юм биш үү гэдгийг хэлмээр байна.

Тэгэх юм бол тэр бизнес хэл гэдэг чинь энэ яамныхны, бидний ярьдаг юмнаас шал ондоо зүйл байдаг юм байна. Тэгээд цаашдаа ийм чиглэл барьж ажиллаж байвал үр дүнтэй болох гээд байгаа юм шиг байна шүү гэдгийг л хэлэх гэсэн юм. Ийм гурван санал хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Яах вэ, энэ гэрээ хэлэлцээрүүд манайхан өөрсдөө гүйж очоод л янз бүрийн байдлаар тэгнэ ингэнэ гээд л. Энэ чинь В.Путин Ерөнхийлөгчийг ирэхэд 2024 онд л яригдаж байсан юм байна шүү дээ. Тэгээд өнөөдөр чинь 2026 он шүү дээ.

Нөхцөл байдал өөр л болсон байгаа. Ахиад нэг хэдэн сарын дараа нөхцөл байдал бүр өөр болно. Хойд хөрш маань дайнтай л байна. Хуучин цэргийн тусгай ажиллагаа гээд бид хэлж чаддаггүй л байсан. Одоо бол дайн. Хоригтой байгаа.

Ер нь хувийн хэвшил л ажил төрлийг сайн амжуулаад ирдэг шүү дээ.

Маш хямдхан бензин авч байна гээд байх юм. Агаарын түлш авч байна гээд байх юм. Тийм л юм бол одоо тэгээд яагаад өнгөрсөн намар бензин түлш нь тасалдаад байсан юм. Яагаад онгоцны билетийн үнэ чинь буудаггүй юм. ийм хямдхан аваад байгаа юм бол билетийнхээ үнийг буулга л даа.

МИАТ чинь төрийн өмчтэй л компани биз дээ. Гэх мэтчилэнгийн. Тэр “Монатом”, “Росатом” хоёр гэрээ хийгээд л баахан ураны төсөл хэрэгжүүлнэ гэсэн. Тэгээд худлаа болсон.

Тэгээд дараа нь Монгол Улс яасан. Монгол Улс ч юу байх вэ. Ард түмэн л төлж байгаа байхгүй юу. 60, 70 сая долларын төлбөр төлсөн шүү дээ. Тэр гэрээгээ болилоо гээд.

Ийм юм гарахгүй гэсэн баталгаа байхгүй. Одоо жоохон юм намжсаны дараа наадхаа яривал яасан юм. Яг одоо ийм хүнд хэцүү, бензин түлш тасалдаж магадгүй ч юм уу, дэлхий нийтээрээ байгаа яг ийм үед нь ийм гэрээ хэлэлцрээ яриад, үүгээр далимдуулаад, чоно борооноор ч гэдэг билүү. Тийм ээ. Хүмүүсийн

сэтгэл санаа ийм байх үед баталгаатай юм хийх гэж байна гээд иймэрхүү нэг худлаа үнэн юм яриад ингэж яваад хэрэггүй байх.

Тэгээд ер нь танайх ч тэгээд сая 2024 оны сонгуулиар 35 хувийн л санал авсан л нам шүү дээ. Ард түмний саналыг бүрэн дүүрэн авсан тийм юм байхгүй шүү дээ.

Тэгээд улс орны 15, 20 жилийн юмыг шийдээд байдаг. Тийм. Тийм л байгаа шүү дээ.

Тэгээд өмнө 10 жил засаглаж байсан. Тэр сав суулгаа бэлдэж байхгүй уугаа хийж байсан юм. Яагаад ард түмнийг хохироогоод байдаг юм. Тэр мөнгө төгрөгийг нь.

Эхлээд би ярья. Энэ инээд биш ханиад болно шүү.

Ер нь бид ил тод юмаа ярьдаг байх нь зөв байгаа юм. Үүнийгээ хэлж байж манай Их Хурал гэдэг чинь ингэдэг юм. Цаанаас нь ард түмэн шахаж шаарддаг юм. Тэгж ярьж байж наад гэрээ хэлэлцээрээ арай дээр болох ёстой байгаа юм шүү. Тэр үүднээс хандаж байгаарай. Уг нь тэгдэг ч байсан. Одоо баахан шинэ гишүүдтэй болсон. Тийм ээ. Тэр уламжлалаа мартсан ч юм уу, ямар ч байгаа юм. Нэг тийм ойлгомжгүй л байдалтай байна. Манай давуу тал чинь тэр байхгүй даа. Энэ хоёр орныхоо дунд.

Энэ хоёр хөрш маань дандаа л наанатай цаанатай ханддаг. Бид мөнхийн хөршүүд. Юмаа ойлголцож, ойлгуулж хийх ёстой. Гэвч тэгдэггүй. Өөрсдөө нэг их сүрхий хүн болж гүйж очиж байгаад л ийм болдог. Эцсийн эцэст хувийн хэвшил л ийм үед сайн гэрээ хийж чаддаг шүү дээ. Жишээ гэхэд Эрдэнэтийн 49. Түүний хүчинд ковид, энэ хүртэл бүх хүндрэлүүдийг давлаа шүү дээ. Ийм л байгаа шүү дээ.

Д.Цогтбаатар: Л.Гантөмөр гишүүн үг хэлье гэсэн. Л.Гантөмөр гишүүний микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Би нөхцөлтэйгөөр дэмжиж байгаа.

Хоёр улсын хооронд хийсэн гэрээ хэлэлцээрүүд бүгдээрээ ажил хэрэг болох ёстой. Энэ бол зарчим байна. Үүнийг би албаар протоколд тэмдэглүүлж байгаа. Гадаад яаманд Аюулгүй байдлын байнгын хороо чиглэл өгөх шаардлагатай.

Юу гэхээр энэ гэрээ Их Хурлаар соёрхон батлагдахтай зэрэгцүүлээд дизель түлш, бензиний хангамжийн тэр гэрээ амилах ёстой. Тэр гэрээ шууд босож ирэх гэдэг зүйлийг Гадаад яам заавал чекэлж явж байх ёстой. Нэг.

Хоёрдугаарт, “Эгийн голын цахилгаан станцын асуудал”-ыг **яаралтай шийдэх хэрэгтэй**. Тэр яг энэ агаарын түлшний гэрээтэйгээ адилхан хойшлоод байгаа юм.

Тэгэхээр энэ хоёр асуудалтайгаа ядаж уяатайгаар бид Оросын Холбооны Улсын талын саналыг Монгол Улсын парламент дэмжих тал дээр гарч ирж байгаа шүү гэдгийг бүгдээрээ ойлгох хэрэгтэй.

Түүнээс биш бид Ормузын хоолой хаагдсантай холбоотойгоор энэ санал парламент дээр дэмжигдэж байна гэдэг буруу тайлбар, буруу ойлголт цаашаа явж болохгүй гэдгийг хэлье. Дэмжиж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Би Байнгын хороон дарга биш. Гэхдээ нэгэнт түр орлоод сууж байгаа бол сая гишүүдийн хэлж байгаа санаануудыг Та нар ажилдаа тусгаж аваарай. Холбогдох яамдууд тусгаж аваарай.

Тэгээд энэ хийх ёстой ажлууд маш их байгаа шүү.

Тэгээд би үүгээр дуусгая. Ярих дээрээ тулах юм бол ярих асуудлууд маш их байгаа.

Тэгээд Г.Дамдинням сайдтай ярих биш. Ярих асуудал өөр газар байгаа. Гэхдээ Г.Дамдинням сайд энэ лайг нь Н.Тавинбэх сайд, би олон сайд нарыг хэлж болно. Үүрээд яваад байгаа. Шийдээд яваад байгаа.

Гэхдээ танай засгийн ажил гэдэг чинь багийн л ажил шүү. Түүнээс бусдыг нь дутуу ажилласныг өөр сайд нар нөхөөд хийгээд яваад байдаг тийм асуудал байхгүй. Зүгээр боломжгүй учраас ийм асуудалд ороод яваад байгаа гэдгээ тал талдаа анхаарна биз.

Тэгээд нэгэнт гишүүд үг хэлж дууссан болохоор одоо санал хураалтдаа бэлдэнэ. Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Д.Энхтүвшин гишүүнийх ороогүй л байх шиг байна. Бүгдээрээ бэлэн үү?

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт. /алх цохив/

70.6 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин гишүүн нэгдсэн хуралдаанд илтгэж танилцуулна. /алх цохив/

Ингээд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал хэлэлцэгдэж дууссан тул хуралдаан ажлаа өндөрлөж байна. Идэвхтэй оролцсон гишүүддээ талархал илэрхийлье. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 14 минут үргэлжилж, 14 цаг 59 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

ЦАЛТАН-ОД